



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/335/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261628 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Энхжин  
Утас: 261628 Цахим хаяг: [ehkhjinb@audit.gov.mn](mailto:ehkhjinb@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК  
Захирал: Д.Ариунаа  
Цахим хаяг: [arifin.audit@gmail.com](mailto:arifin.audit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
4.1.Төлбөрийн акт.....	13
4.2. Зөвлөмж .....	13
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ  
ТӨВИЙН ДАРГА А.ОЮУНЧИМЭГ  
ТАНАА

2022.02.25 № 07/374  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын санал дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 44,175.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>17,982,150.00</b>	<b>18,802,425.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>17,982,150.00</b>	<b>18,802,425.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>17,982,150.00</b>	<b>18,802,425.00</b>
35410	Бичиг хэргийн материал	905,230.00	865,540.00
35420	Аж ахуйн материал	16,725,620.00	17,753,785.00
35440	Түлш, шатах тослох материал	351,300.00	183,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>211,608,437.84</b>	<b>172,760,816.66</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>211,608,437.84</b>	<b>172,760,816.66</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>187,686,104.42</b>	<b>143,939,150.12</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77,068,664.92	77,068,664.92
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,847,170.94)	(73,847,170.94)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	267,645,632.00	269,900,632.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(114,462,058.03)	(162,128,677.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,192,590.00	54,192,590.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,911,553.53)	(21,246,888.62)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>23,922,333.42</b>	<b>28,821,666.54</b>
39301	Программ хангамж	34,304,000.00	42,004,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,381,666.58)	(13,182,333.46)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>229,590,587.84</b>	<b>191,563,241.66</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>229,590,587.84</b>	<b>191,563,241.66</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>229,590,587.84</b>	<b>191,563,241.66</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>229,590,587.84</b>	<b>191,563,241.66</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	227,407,467.58	229,590,587.84
51220	Тайлант үеийн үр дүн	2,183,120.26	-38,027,346.18
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>229,590,587.84</b>	<b>191,563,241.66</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,319,502,189.00</b>	<b>1,145,336,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,171,989.00</b>	<b>228,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,171,989.00</b>	<b>228,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,911,989.00</b>	<b>228,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,260,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	312,000.00	228,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,599,989.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,316,330,200.00</b>	<b>1,145,108,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,316,330,200.00</b>	<b>1,145,108,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,316,330,200.00	1,145,108,700.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,317,319,068.74</b>	<b>1,183,364,046.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,317,319,068.74</b>	<b>1,183,364,046.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,173,207,002.94</b>	<b>1,179,561,169.30</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>858,201,022.24</b>	<b>843,469,396.00</b>
210101	Үндсэн цалин	721,823,443.87	727,290,269.00
210102	Нэмэгдэл	82,251,278.37	62,911,904.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,824,300.00	19,165,223.00
210104	Урамшуулал	40,302,000.00	34,102,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>105,510,327.78</b>	<b>108,221,730.55</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,588,527.78	67,299,830.55
210202	Тэтгэмжийн даатгал	10,230,400.00	10,230,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,184,400.00	8,184,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,000.00	2,046,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,461,000.00	20,460,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,540,700.00</b>	<b>107,888,040.00</b>
210304	Байрны түрээс	61,540,700.00	107,888,040.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,343,205.18</b>	<b>36,088,356.57</b>
210401	Бичиг хэрэг	9,650,312.00	9,206,890.00
210402	Тээвэр, шатахуун	9,912,000.00	8,088,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,695,824.18	10,202,531.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,085,069.00	5,358,355.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	3,232,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,320,340.00</b>	<b>3,125,625.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,119,100.00	0.00
210604	Урсгал засвар	13,201,240.00	3,125,625.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,216,100.00</b>	<b>3,054,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,216,100.00	3,054,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,179,920.00</b>	<b>13,886,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,390,820.00	9,187,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	499,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	210,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,039,100.00	3,866,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,895,387.74</b>	<b>63,827,021.18</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,886,200.00	8,024,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,009,187.74	55,802,621.18
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>144,112,065.80</b>	<b>3,802,876.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,024,000.00</b>	<b>2,419,200.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,000,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,024,000.00	2,419,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>126,088,065.80</b>	<b>1,383,676.88</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,088,065.80	1,383,676.88
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,183,120.26</b>	<b>(38,027,346.18)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>2,183,120.26</b>	<b>(38,027,346.18)</b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>227,407,467.58</b>	<b>227,407,467.58</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>227,407,467.58</b>	<b>227,407,467.58</b>
Тайлант үеийн үр дүн			2,183,120.26	2,183,120.26
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>229,590,587.84</b>	<b>229,590,587.84</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>229,590,587.84</b>	<b>229,590,587.84</b>
Тайлант үеийн үр дүн			(38,027,346.18)	(38,027,346.18)
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>191,563,241.66</b>	<b>191,563,241.66</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,317,590,200.00</b>	<b>1,145,108,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,260,000.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,260,000.00</b>	<b>0.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,260,000.00</b>	<b>0.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,260,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,316,330,200.00</b>	<b>1,145,108,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,316,330,200.00</b>	<b>1,145,108,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,316,330,200.00	1,145,108,700.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,268,728,300.00</b>	<b>1,128,153,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,268,728,300.00</b>	<b>1,128,153,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,124,616,234.20</b>	<b>1,124,350,823.12</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>858,201,022.24</b>	<b>843,469,396.00</b>
210101	Үндсэн цалин	721,823,443.87	727,290,269.00
210102	Нэмэгдэл	82,251,278.37	62,911,904.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,824,300.00	19,165,223.00
210104	Урамшуулал	40,302,000.00	34,102,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>105,510,327.78</b>	<b>108,221,730.55</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,588,527.78	67,299,830.55
210202	Тэтгэмжийн даатгал	10,230,400.00	10,230,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,184,400.00	8,184,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,000.00	2,046,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,461,000.00	20,460,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,540,700.00</b>	<b>107,888,040.00</b>
210304	Байрны түрээс	61,540,700.00	107,888,040.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>49,542,624.18</b>	<b>34,101,931.57</b>
210401	Бичиг хэрэг	9,659,500.00	9,167,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,789,300.00	7,691,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,695,824.18	10,202,531.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,398,000.00	7,040,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,460,140.00</b>	<b>4,462,325.00</b>

210601	Багаж, техник, хэрэгсэл	6,343,000.00	1,336,700.00
210604	Урсгал засвар	11,117,140.00	3,125,625.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,216,100.00</b>	<b>3,054,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,216,100.00	3,054,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,259,120.00</b>	<b>13,886,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,470,020.00	9,187,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	499,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	210,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	122,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,039,100.00	3,866,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,886,200.00</b>	<b>9,266,400.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,886,200.00	9,266,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>144,112,065.80</b>	<b>3,802,876.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>18,024,000.00</b>	<b>2,419,200.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,000,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,024,000.00	2,419,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>126,088,065.80</b>	<b>1,383,676.88</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,088,065.80	1,383,676.88
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>48,861,900.00</b>	<b>16,955,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>48,861,900.00</b>	<b>16,955,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>48,861,900.00</b>	<b>16,955,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>48,861,900.00</b>	<b>16,955,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	48,861,900.00	16,955,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-48,861,900.00</b>	<b>-16,955,000.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,145,108,700.00</b>	<b>1,143,725,023.12</b>	<b>1,383,676.88</b>	<b>99.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,145,108,700.00</b>	<b>1,143,725,023.12</b>	<b>1,383,676.88</b>	<b>99.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,142,689,500.00</b>	<b>1,141,305,823.12</b>	<b>1,383,676.88</b>	<b>99.9</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>844,264,400.00</b>	<b>843,469,396.00</b>	<b>795,004.00</b>	<b>99.9</b>
210101	Үндсэн цалин	727,767,100.00	727,290,269.00	476,831.00	99.9
210102	Нэмэгдэл	63,156,300.00	62,911,904.00	244,396.00	99.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,239,000.00	19,165,223.00	73,777.00	99.6
210104	Урамшуулал	34,102,000.00	34,102,000.00	-	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>108,311,400.00</b>	<b>108,221,730.55</b>	<b>89,669.45</b>	<b>99.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,389,500.00	67,299,830.55	89,669.45	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	10,230,500.00	10,230,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,184,400.00	8,184,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046,100.00	2,046,100.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	20,460,900.00	20,460,900.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>107,933,700.00</b>	<b>107,888,040.00</b>	<b>45,660.00</b>	<b>100.0</b>
210304	Байрны түрээс	107,933,700.00	107,888,040.00	45,660.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,230,800.00</b>	<b>34,101,931.57</b>	<b>128,868.43</b>	<b>99.6</b>
210401	Бичиг хэрэг	9,167,200.00	9,167,200.00	-	100.0



Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	7,691,800.00	7,691,800.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,331,400.00	10,202,531.57	128,868.43	98.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,040,400.00	7,040,400.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,925,400.00</b>	<b>13,717,325.00</b>	<b>208,075.00</b>	<b>98.5</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,597,400.00	3,591,700.00	5,700.00	99.8
210602	Тавилга	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,328,000.00	3,125,625.00	202,375.00	93.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,054,300.00</b>	<b>3,054,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	3,054,300.00	3,054,300.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,666,200.00</b>	<b>21,586,700.00</b>	<b>79,500.00</b>	<b>99.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,187,800.00	9,187,800.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	499,300.00	700.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,900.00	210,900.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	122,000.00	122,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,566,700.00	11,566,700.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	78,800.00	0.00	78,800.00	0.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,303,300.00</b>	<b>9,266,400.00</b>	<b>36,900.00</b>	<b>99.6</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,303,300.00	9,266,400.00	36,900.00	99.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,419,200.00</b>	<b>2,419,200.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,419,200.00</b>	<b>2,419,200.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,419,200.00	2,419,200.00	-	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,145,108,700.00</b>	<b>1,143,725,023.12</b>	<b>1,383,676.88</b>	<b>99.9</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,145,108,700.00</b>	<b>1,143,725,023.12</b>	<b>1,383,676.88</b>	<b>99.9</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,145,108,700.00	1,143,725,023.12	1,383,676.88	99.9
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>72</b>	<b>72</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	68	68	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>72</b>	<b>72</b>	<b>-</b>	<b>100.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	61	61	-	100.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдлийг хангах, цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж байх, татварын цахим хуудсанд и-баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлж, авлагыг бүрэн тусгах зэрэг өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын ахлах аудитор Р.Мядагмаа, аудитор Г.Эрдэнэмөнх нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Долгорсүрэн, захирал Д.Ариунаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ари Файнэнс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хууль зүйн туслалцааны төвийн зорилго нь төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад оршино. Хүний эрх, эрх чөлөөг хангасан дэд бүтцийг бэхжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн, өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,317,319.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,173.2 мянган төгрөгөөр, тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,027.3 мянган төгрөгөөр буюу 16,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	17,982.1	18,802.4	820.3
Үндсэн хөрөнгө	211,608.4	172,760.8	(38,847.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>229,590.6</b>	<b>191,563.2</b>	<b>(38,027.4)</b>
Өр төлбөр			
Хуримтлагдсан үр дүн	229,590.6	191,563.2	(38,027.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>229,590.6</b>	<b>191,563.2</b>	<b>(38,027.4)</b>

Бараа материалын үлдэгдэл 18,820.4 мянган төгрөг болж 820.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын үлдэгдэлд бичиг хэргийн материалын дансанд 865.5 мянган төгрөг, аж ахуйн материалын дансанд 17,753.8 мянган төгрөг, түлш, шатах тослох материалын дансанд 183.1 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө урсгал төсвөөс бэлтгэсэн 16,955.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант үеийн 38,847.6 мянган төгрөгийн элэгдлийн дүнгээр буурсан байна.

Хуримтлагдсан үр дүн 191,563.2 мянган төгрөг болж 38,027.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 174,165.5 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 133,995.5 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн, НДШ-ийн, байр ашиглалтын, хангамж бараа материалын, эд хогшил, урсгал засварын, бусдаар

гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлууд байна. Энэ нь эд хогшил, урсгал засварын зардал бага бэлдсэн, цалин, НДШ-ийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,619,486.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,619,486.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,474,377.8 мянган төгрөгөөр бууруулж 1,145,108.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,145,108.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,145,108.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,143,725.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,143,725.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70710 Төлбөрийн чадваргүй яллагдагч, сэжигтэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх	1,145,108.7	1,143,725.0	1,383.7	99.9
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,138,013.5	1,136,629.8	1,383.7	99.9
1.2	80213 Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	4,676.0	4,676.	-	100.0
1.3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,419.2	2,419.2	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

#### Асуудлыг онцолсон хэсэг

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөл, шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий мэргэшсэн, тогтвортой ажиллах, төлбөрийн чадваргүй гэмт хэрэгт холбогдсон иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хуульчийг улсын өмгөөлөгчөөр сонгон шалгаруулж Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-

Уул, Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд болон Дорнод, Булган, Хэнтий, Баян-Өлгий аймаг дахь салбарт нийт 9 өмгөөлөгчийг томилон ажиллуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Хууль зүйн туслалцааны төвийн тайлан, мэдээллийг бүрэн цахимжуулж, иргэд хууль зүйн туслалцаа хүссэн өргөдлийг цахимаар ирүүлэх, шийдвэрлүүлэх, мэдээлэл солилцох, түгээх үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл боломжийг бүрдүүлэхээр “Дижитал индустри” ХХК-тай 2021 оны ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, программ хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэн, гүйцэтгэл 90.0 хувьтай байна.

### **Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдаас “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу Хууль зүйн туслалцааны төвөөс 2021 онд 3 зорилтын 7 арга хэмжээг төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### **3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс 913,115.6 мянган төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 44,175.9 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 3,003.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 41,172.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 44,175.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалтай” дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

#### **4.1.Төлбөрийн акт**

Байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 3,003.1 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайлагналд тусгахыг хориглоно.” Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 “Зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал/цүнх, календарь, мэндчилгээ гэх мэт/-ын зардал гаргахгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

#### **4.2. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1.Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

###### **1.1 Илрүүлэлт:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй бараа, ажил үйлчилгээний 38,276.8 мянган төгрөгийн цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй, татварын цахим хуудсанд и-баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", гэж заасантай нийцээгүй, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа цахим баримтыг тухай бүрд нь бүрдүүлэх, татварын и-баримт цахим хуудсанд бэлтгэн нийлүүлэгч и-баримтыг шивсэн эсэх болон анхан шатны баримтын бүрдэлтэд тавих хяналтыг сайжруулах.

##### **2.Балансын данстай холбоотой асуудал**

###### **2.1 Илрүүлэлт:**

Татварын байгууллага болон нийгмийн даатгалын хэлтэст илүү шилжүүлсэн 2,896.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7-д "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

###### **2.2 Өгсөн зөвлөмж:**

Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Хууль зүйн туслалцааны төв	АХГ-2022/335/НА-СТА-ТШЗ	Байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр бэлэг дурсгалд зарцуулсан	Холбогдох албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх	1	3,003.1			1	3,003.1				
2	Хууль зүйн туслалцааны төв	АХГ-2022/335/НА-СТА-ТШЗ	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шаардаж бүрдүүлээгүй байна.	Цахим и-баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас бүрдүүлэх, татварын цахим хуудсанд баримтын шивэлтийг хянах	1	38,276.8							1	38,276.8
3	Хууль зүйн туслалцааны төв	АХГ-2022/335/НА-СТА-ТШЗ	Татварын байгууллага болон нийгмийн даатгалын хэлтэст илүү шилжүүлсэн 2,896.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх	1	2,896.0							1	2,896.0
<b>ДҮН</b>					<b>3</b>	<b>44,175.9</b>			<b>1</b>	<b>3,003.1</b>			<b>2</b>	<b>41,172.8</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Хууль зүйн туслалцааны төв	АХГ-2022/335/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах мэдээллүүдийг мэдээлээгүй, хугацаа хоцроосон байна.	Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлж байх	1	913,115.6					1	913,115.6		
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>913,115.6</b>					<b>1</b>	<b>913,115.6</b>		
<b>НИЙТ ДҮН</b>					<b>4</b>	<b>957,291.5</b>			<b>1</b>	<b>3,003.1</b>	<b>1</b>	<b>913,115.6</b>	<b>2</b>	<b>41,172.8</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 13/АД150055  
АХГ-0000/335/МА-СТА-ТМЗ  
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын тушаал, шийдвэргүйгээр 3,003,145.00 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж, зарцуулсан.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайлагналд тусгахыг хориглоно.”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 “Зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал/цүнх, календарь, мэндчилгээ гэх мэт/-ын зардал гаргахгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсвийг үр ашиггүй зарцуулсан 3,003,145.00 /Гурван сая гурван мянга нэг зуун дөчин тав/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хууль зүйн туслалцааны төвийн дарга А.Оюунчимэг, нягтлан бодогч Б.Хажидмаа нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

  
  
Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
Д.АРИУНАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherem\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-16.Docx

001090064



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 46/АОИС0055  
АХГ-2022/335/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 913,115,640.00 төгрөгийн 19 ажил гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай, мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд байршуулахад тавих дотоод хяналтыг сайжруулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг даван гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүйн туслалцааны төвийн дарга А.Оюунчимэг, нягтлан бодогч Б.Хажидмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ

Д.АРИУНАА